



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН
ГУРВАН ТАЛТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот
Утас: 51-263035

Дүрэмд нэмэлт оруулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалт, 155 дугаар зүйлийн 155.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны дүрэм"-ийн 4-т доор дурдсан агуулгатай "4.11, 4.12, 4.13" дахь хэсгийг тус тус нэмсүгэй:

"4.11. Хорооны гишүүдэд хуралдаанд оролцсон ирцийг харгалзан улирал бүр урамшуулал олгох бөгөөд нэг цагийн урамшууллын хэмжээ нь Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос баталсан хөдөлмөрийн хөлсний нэг цагийн доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

4.12. Хорооны үйл ажиллагаа /бичгийн хэрэгсэл, хэвлэх олшруулах болон бусад/-ны зардлыг хагас жил тутамд нэг удаа олгох бөгөөд зардлын хэмжээ нь Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос баталсан хөдөлмөрийн хөлсний нэг сарын доод хэмжээтэй адил байна.

4.13. Энэ дүрмийн 4.11, 4.12-т заасан зардлыг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ." гэж тус тус нэмсүгэй.

ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД

Т.АЮУРСАЙХАН



МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ ЭЗДИЙН
НЭГДСЭН ХОЛБООНЫ ДЭД
ЕРӨНХИЙЛӨГЧ



С.ЭРДЭНЭБАТ



Х.ГАНБААТАР